

**Тайваны эрдэмтэн Чан Чи Сионы
«Гадаад Монголын үндэсний нэгдэл буюу
тусгаар тогтнол, бие даасан байдал»
(1911 –1916) номын тухай шүүмж**

О.БАТСАЙХАН

Chi Hsiung Chang “Disputes and Negotiations over Outer Mongolia’s National Identity, Unification or Independence and Sovereignty” 1911-1916 An Observation based on the Principle of the Chinese World Order published by the Institute of Modern History, Academia Sinica Taipei, Republic of China in 1995.

Тайваны дорно дахин судлаач эрдэмтэн Чан Чи Сион «Гадаад Монголын үндэсний нэгдэл буюу тусгаар тогтнол, бие даасан байдал» (1911 –1916) номоо 1995 онд Тайваны Шинэ түүх судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлжээ.

XX зууны Монгол улсын түүхийн нэн эгзэгтэй үе болох 1911 – 1916 оныг хамарсан үеийн түүхийн зарим асуудлууд, түүний дотор 1915 оны Хятад, Орос, Монгол гурван улсын гэрээнд шууд холбогдох хятад эх сурвалжыг ашиглан нилээд сонин бүтээл бичиж хэвлүүлжээ. Үнэнийг ярьвал бидэнд хятад сурвалж, тэр тусмаа Тайваны архивт байдаг Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд тэр бүр хүртээл бага байдаг билээ. Эл бүтээл энэ үед холбогдох архив, номын сангийн маш их материал ашигласнаараа онцлог бүтээл болсон байна. Эрдэм шинжилгээний бүтээлийн хувьд судалгаа, шинжилгээний бүрдэл нилээд сайн болсон байна. Доктор Чангийн эл ном нь Тайваны эрдэмтэд Монгол улсын түүхийн зарим асуудалд нилээд анхаарал тавьдагийн жишээ хэмээн үзэж болмоор санагдлаа. Эл бүтээл нь дөрвөн бүлэг, оршил, дүгнэлт, ном зүй, хавсралт хэмээсэн хэсгүүдээс бүрджээ.

Нийт 366 хуудастай. Харин бүлэг тус бүр нилээд олон зүйлтэй байх бөгөөд тухайлбал, «Оросын явуулгын дор Хятад, Монголын бие даасан нэгдэлд зөрчил гарсан нь» хэмээх нэгдүгээр бүлэгт нийт 7 зүйлтэй байх ба, «Хятад, Оросын Бээжин дэхь хэлэлцээрээр Гадаад Монголын бүрэн эрхийг буцаан хязгаарласан нь» хэмээх хоёрдугаар бүлэг 6 зүйлтэй, «Хятад, Орос, Монгол гурван талын хэлэлцээр, хэлэлцээрийн байр суурь ба тухайн үеийн байдал» хэмээх гуравдугаар бүлэг 5 зүйлтэй, «Жавзандамба хутагтын хүнд байдал ба хязгаарлагдмал байдал» хэмээх

• О.Батсайхан - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, түүхийн ухааны доктор (Ph), дэд профессор

дөрөвдүгээр бүлэг 3 зүйлтэй бичигдсэн байна. Мөн зүйл бүрийн дотор жижиг гарчгаар ангилан, их л хичээсэн нь илт байна. Хэдийгээр номын дотор бичигдсэн зарим, санаа дүгнэлттэй санал нийлэхгүй зүйл байгаа хэдий ч уг бүтээл эрдэмтэн судлаачийн байр сууринаас хандсан судалгаа шинжилгээний ном болсон нь гарцаагүй зүйл юм. Гэвч зарим нэгэн асуудлыг их гүрний эрх ашигт нүүдүүлэн бичсэнийг нь тэмдэглэх хэрэгтэй буй за.

Эл бүтээл нь Монголын түүхэнд холбогдох эерэг болон сөрөг нилээд мэдээлэл агуулж байгаа нь бидний хувьд сонирхолтой байгаа юм.

1911 оны Монголын тусгаар тогтнолын асуудал нь Орос, Хятадын Монгол дахь эрх ашгийн асуудалтай холбоотой байсан учраас гурван талын асуудал нэг цэг дээр хөндөгдөж, улмаар гурван этгээдийг хэлэлцээрийн ширээний ард Хиагтад 1914 оны намар суулгах болсон юм.

Зохиогч «Хятад, Орос, Монгол гурван талын гэрээ хэлэлцээрийн байр суурь ба тухайн үеийн байдал» хэмээх гуравдугаар бүлгийн нэгдүгээр зүйлдээ гурван улсын хэлэлцээрт оролцогч талуудын байр суурийг тодорхолсон байна. Тухайлбал, Ар Монгол тусгаар тогтнолоо тунхаглаж, Хятадтай харилцаагаа таслах бодолтой байсан хэмээн Монголын байр суурийг бичсэн бол Хятад улс Монгол дахь эзэнт эрхээ сэргээх бодолтой бөгөөд үүнийгээ хэлэлцээрээр шийдвэрлүүлэх эрмэлзэлтэй байв гэж тэмдэглэжээ. Харин Оросын хувьд бол урьдын хэвийн байдлаа хадгалж үлдэх эрмэлзэлтэй байсан тул Ар Монгол дахь эрх ашгаа хадгалах сонирхолтой байв гэжээ.

Хиагтын хэлэлцээр нь өнгөн дээрээ Хятад Монгол хоёрын хагарал маргааныг шийдвэрлэхийн тулд эхэлсэн хэлэлцээр мэт боловч Орос улс хоёр талын зөрчлийг аль ч талд нь оролгүйгээр маргааныг зогсоох гэсэн дүр эсгэж байв. Үнэн хэрэг дээрээ Орос улс Монгол дахь эрх ашгаа хууль ёсны болгож авахын тулд их гүрний хандлагаар шахалт үзүүлэх байдлаар гол дүрд тоглож, албан ёсны бүх хэлэлцээрт оролцохын зэрэгцээгээр цаанаа хэлэлцээрийн бүх үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй байв. Тэгэхэд Ар Монгол өнгөн дээрээ бүх хэлэлцээрт албан ёсоор оролцож байсан хэдий ч хэлэлцээрийг зохицуулах гол гол хурлуудын гадны хоцордог байв хэмээн тэмдэглэжээ. Түүгээр ч үл барам Хятад Орос, Монгол гурван талын хэлэлцээр гэж яригддаг боловч Ар Монголын хэргийг шүүн таслах Хятад, Оросын хоёр талын хэлэлцээр болсон юм гэж хэлэхэд ч хэтрүүлэг болохооргүй байв хэмээн Монголын талын оролцоог илт үгүйсгэсэн өрөөсгөл дүгнэлт хийжээ.

Хэлэлцээр эхлэх хугацааг товлох асуудал удаа дараа хойшилж зөвхөн Монголын талын шийдвэрийг хүлээж байсаар сая Монголын засгийн газрын шийдвэр гарч, улмаар 1914 оны 8 сарын 14 нд Орос улсаас Хятадад суугаа элчин Хятадын Гадаад яаманд хэлэлцээр эхлэх цаг ба газрыг мэдэгдэв. Ийнхүү монголын талын товлосон 1914 оны 9 дүгээр сарын 8 нд Хиагтад хэлэлцээр эхэлсэн нь үнэн түүх бүлгөө.

Эл хэлэлцээрт Монголын талаас: Монголын талаас: Төлөөлөгчдийн тэргүүн Монгол улсын Дотоод явдлын яамны тэргүүн сайд „Нэйс билигт улсад туслагч да лам Дашжав (Ширнэндамдингаар сольсон), гишүүн Сангийн яамны тэргүүн түшээ гүн Чагдаржав, зөвлөх Гадаад яамны дэд сайд хичээнгүй гүн Цэрэндорж, Өвөр Монголын засагт ван Удай, гүн Жигжиджав, Баргын Манлай ван Дамдинсүрэн, Эх зохиогч бичээч бөгөөд орчуулагч түшмэл Жамсрангийн Цэвээн, Цогт Бадамжав, эх зохиох бичээч Санжмятав нар оролцсон билээ. Хэлэлцээрийн туршид Монголын Засгийн газрын санал хэлэлцэгдэж, улмаар хэлэлцээрийн шийдвэрт зохих тусгалаа олсон хэмээн үзэх бүрэн үндэслэл байгаа билээ.

Уг зохиогчийн бичсэнээр 8 дугаар сарын 29 ний өдөр Хятад улсаас хэлэлцээрт оролцох бүрэн эрхт тусгай элч Би Гуй Фан, Чэнь Лу нар Бээжин хотоос гарчээ. Хятадын хоёр элч гарахаасаа өмнө ноён Ерөнхийлөгчид бараалхаж дөрвөн зүйлийн заавар зөвлөгөөг авсан байв. Эл дөрвөн зүйл нь: нэгд, Мэдэгдэл бичгийг зөвшөөрөх, хоёрт, тусгаар тогтнол гэдгийг хүчингүйд тооцох, гуравт, Олноо өргөгдсөн оны цолыг хүчингүй болгох, дөрөвт, хааны цолыг хэрэгсэхгүй болгож Жавзандамба гэдэг нэрээрээ явах зэргийг хэлэлцээр эхлэх болзол болгон тавьж Ар Монголоор зөвшөөрүүлэх нь зүйтэй гэжээ.

Энэ дөрвөн болзлыг урьдаар шийдэх явдал бол Хятадын талаас хэлэлцээрт оролцох хамгийн эрхэм зааварчлага байв. Хятад улсын байр суурь нь Хятад улс Ар Монгол дахь эзэнт эрхээ хадгалах, «Ар Монголын өөртөө засах эрхийг зөвшөөрч болох юм» гэхдээ Ар Монголыг зөвхөн Хятад улсын нутаг дэвсгэрийн хувьд өөртөө засах байр суурийг зөвшөөрөх гэсэн асуудал байв хэмээн зохиогч тэмдэглэжээ.

Зохиогчийн бичсэнээр «Хэрэг явдлын үнэн байдал гэвэл Хятад Монголын хууль ёсны харилцаа нь шийдэгдсэн гэх боловч эрх ашиг нь Орост алдагдаж улмаар Ар Монгол Хятадын мэдэлд байна гэдэг нь хоосон зүйл болж байсан тул олон улсын харилцаанд ч хоосон орон зай хэвээр байв гээд Ар Монгол «эзэнт эрхийн мэдэлд харьяалагдаж байгаа улс бус өөртөө засах улс» болж чадаад «тоглоомын хэлбэртэй эзэнт эрх бүхий улс» болсон гэх зэргээр Монголын байдлыг дүгнэсэн

байна. Эндээс Оросын Монгол дахь эрх ашгаа бэхжүүлж чадсан хэмээх нь үнэний ортой буй за. Монгол дахь Оросын ашиг сонирхол бэхжих нь оросуудад төдийгүй Монголчуудын ашиг сонирхолд ямар нэгэн хэмжээгээр нийцтэй байсан юм.

Хэлэлцээрт оролцсон Монголын байр суурь ямар байв хэмээвээс Монголчууд улс төрийн тогтолцоо болон үйлдвэр худалдаа, төмөр зам, цахилгаан холбоо болон санхүү эдийн засгийн асуудал зэрэг дотоод засаг захиргааны бүх талын ажил болон бусад улс гүрэнтэй найрамдан ирж очих асуудлаар өөрийн эзэнт эрхийн шинж чанарыг агуулж байхад Орос, Хятад хоёр улсын баталгаа ба зөвшөөрлийг олно байх гэж найдна. Иймд Монголын засгийн газар Хятад Орос хоёр улс дээрх явдалд хориг тавихгүй байх, Монгол руу цэрэг илгээж сууршуулахгүй байх, монголд цэргийн явдлын болон захиргааны түшмэдийн алба байгуулахгүй байх, дахин манай улсыг эзэмшил улс болгохгүй байх гэж үзэж байгаа бөгөөд энэ нь Монгол улс улс төрийн талаар бүрмөсөн тусгаар тогтнож найрамдан оршиход түшиглэн явахын баталгаа болно гэсэн чин эрмэлзлэл Монголчууд өвөрлөж байсаныг үнэн бодитоор тусгасан нь сайшаалтай хэрэг юм.

«Хятад улс Монголд эзэнт эрхтэй хэвээр байх гэсэн боловч Ар Монгол тусгаар тогтнолоо тунхагласнаас хойш Хятад улсын Монгол дахь эзэнт эрх аажмаар Ар Монголын хилийн гадна талд шахагдав» хэмээсэн нь Монголын засгийн газраас явуулж байсан бодлоготой холбоотой хэрэг билээ.

«Хятад улс аль болохоор эрх ашиг, нэр төрөө хадгалах үүднээс Орос улсын хүсэлтийг хангаж байсан юм. Нэр төрөө бодохын тулд Хятад улс Орос улсын сүр хүчийг эсэргүүцэх хүчин үл хүрэх байдалд Орос Монгол хоёрын хооронд зөрчил бий болгож Оросоос Монголд үзүүлж байгаа дарамтыг Хятад улсын засгийн газарт танилцуулснаар зэвсгээр солио хийх эсвэл харилцааны явцад өөрт унацтай хэлэлцээр хийх зэрэг аргыг хэрэглэж байсан» гэх зэргээр тухай үеийн хятад оросын харилцааны зарим асуудлыг сөхөн тавьсан байна.

Зохиогч их үндэстний эрх ашгийн үүднээс хятад үндэстэн бусад үндэстнүүдээ манжийн дарангуйлалыг түлхэн унагаахад уриалсан гэх буюу монгол, түвд зэрэг үндэстний олон түмэнд үндэстний асуудлыг өөрөө шийдвэрлэх хүсэл эрмэлзлэлийг нь сэргээсэн юм хэмээн нотлохыг оролджээ.

Мөн түүнчлэн Манжийн төрийн эрх залгамжлагч нь олон улсын хуулиар нэг байх ёстой гэсэн үзэл баримтлалыг гаргаж, цагаагчин гахай жилийн хувьсгал бол нэг улсын засаглалыг өөрчилж, бүгд найрамдах

засаглал болгосон учраас нэгэн төрт ёсны хувьсгал байсан юм. Олон улсын хууль зүйн хувьд төрт ёсны хувьсгал ноёрхогчыг нь өөрчилсөн ч гэсэн улсын эзэнт эрхийн ноёрхолыг бүрмөсөн халах шалтгаан болохгүй. Ингэснээр Дундад иргэн улсын засгийн газар монголыг газар нутагтай нь эзэгнэхийг санаархах нь олон улсын хууль зүйн хувьд зөвшөөрөгдсөн зүйл хэмээн нотлохыг оролджээ. Хятад улс нэг л байгаа гэдэг ойлголтоор манжийн төртэй Хятад гэдэг нь Хятад улс байна, хятадын засаг төрийн эрх үйлчилж байна гэсэн төр ёсны үргэлжлэл болох ухагдхуун байсаар байгааг нэгэн зэрэг харуулж байна хэмээн өөрийн үзэл бодлыг онолын үүднээс зөвтгөн тайлбарлахыг оролдсон байна.

Ар Монголын тусгаар тогтнолын асуудал бол гадаадын дулдуйдснаар хэвшиж буй болсон хуурамч тусгаар тогтнол, улсаа худалдсан асуудал бөгөөд орос монголын худалдааны тусгай зүйл анги нь харилцан бие биенээ дэмжих төдий явж ирснээр жинхэнэ тусгаар тогтнолыг сольж авах аргагүй юм гэх зэргээр Монголын тусгаар тогтносон байдлыг үгүйсгэхийг оролдсон байна.

Ар Монголын нутаг дэвсгэр бол өөртөө засах нутаг болохоос өөртөө засах улс биш юм, тэгэхээр Ар Монголын нутаг дэвсгэр бол бүхэлдээ Хятадын нутгийн нэг хэсэг юм. Тэгэхээр Хятад улс бол Ар Монголыг эзэгнэх эрх бүхий улс юм, Хятад улс бол хан, манж, монгол, уйгар, түвд таван үндэстний нэгэн бүгд найрамдах улс хэмээн дүгнээд «монгол бол дотор газартай нэгэн адил тэгш байх зарчмыг баримтлаж буй» гэдгийг харуулах зорилгоор Монгол түвдийн хэрэг эрхлэх газар байгуулж, төрийн зөвлөл дотор мөн монгол түвдийн хэрэг эрхлэх газар бий болгосон хэмээн тайлбарласан байна.

Тэр үед Ар монгол улсын зорилт нь ойрын буюу холын гэсэн хоёр шаттай байв. Ойрын зорилт нь Хятадын харьяалалаас салж тусгаар тогтносон улс байгуулах явдал байв. Алсын буюу хэтийн зорилт нь бүх монголчуудыг нэгтгэж их Монгол улсыг байгуулах явдал байв гэж зохиогч үзсэн нь гадаадын судлаачдаас 1911 оны Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцлийг үнэлэхэд гардаг төөрөгдөл хэмээн үзэж байна. Учир нь Монголын төрийн зүтгэлтнүүд 1911 онд өөрийн тусгаар тогтнолын төлөө тэмцэлдээ монгол үндэстэн нэгдмэл хүчээр тэмцэж байж сая амжилт олно хэмээн үзсэн учраас үндэснийхээ тусгаар тогтнолын төлөө тэмцэлд монголоо хэмээсэн сэтгэлтэй хэн бүхнийг оролцохыг уриалан дуудаж байсан болохоос бус Их Монгол улсыг байгуулах санаа сэдэх үндэслэл боломж хомс байсан юм. Энэхүү бодит байдлыг Монголын тухайн үеийн төрийн нэрт зүтгэлтнүүд маань сайтар мэдэрч байсан билээ.

Энэхүү Хиагтын 1915 оны гэрээгээр тогтоосон Монгол улсын байдлыг үнэлэх аваас Монгол улс өргөн автономи эрхтэй улс байхыг хоёр хөршөөрөө хүлээн зөвшөөрүүлж чадсан хэрэг юм гэж шүүмж бичигч судлаач миний бие үзэж буй юм. Мөн тухайн үедээ гурван улсын гэрээгээр тогтоосон Монголын байдлыг Монголын төрийн зүгэлтнүүд хэрхэн ойлгож байсаныг дараах баримтаас харж болно. Үүнд: “Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамнаас Богд хаанд айлтгасан “Думдад, Орос, Монголын гэрээ бичгийн утга чанарыг тайлбарласан дэвтэр”-т өгүүлэхдээ: “хүчирхэг нь буурайгаа дарлан элдэв эрх ашгийг булаан эзэрхэхийг хичээх нь олон улс нийтэд бүхий далсан суртал мөн тул эс болгоомжилбоос эс болох... Энэхүү гэрээ бичгийн гол утга болбоос бидний улс хэдий Думдад улсын хэмжээтэй эзэрхэхийг хүлээсэн боловч Думдад улсаас бидний дотоод засгийн буй бүхий хэрэгт оролцох эрх огт үгүй...” хэмээн тэмдэглэсэн байна. Өөрөөр хэлбэл Монголын дотоод хэрэгт Хятад оролцохгүй гэсэн үг билээ. Энэ бол бие даасан улсын адилаар өөрийн дотоод бүхий л асуудлыг шийдвэрлэж болохыг орос, хятад хоёроор хүлээн зөвшөөрүүлж чадсан хэрэг юм.

Олон улсын жишигт хэрэглэж ирсэн уламжлал болон Монголын улсын тухайд хэрэглэсэн автономи хэмээх үгийн утга учирьг нягтлан үзэх аваас,

Автономи - Монголын төлөөлөгчид “автономи” хэмээх үгийг амьдрал дээр хагас эрхтэй улсын хувьд хэрэглэдэг, “сюзеренитет” хэмээх үгийг ямар ч дотоодын мужид хэрэглэдэггүй тул Гадаад Монгол нь өөрийн өвөрмөц байдлыг үндэслэн дотоодын бүх асуудлыг биеэ даан шийдэх эрхтэй гэж тайлбарлаж байжээ.

Харин сюзеренитет хэмээх үгийн тухайд “энэ үг язгуураас Франц хэлнээс гаралтай бөгөөд Дундад улсаас сюзеренитет хэмээх үгийг уг эзний эрх хэмээх ба Орос улсаас энэ нь цөм олон улс нийт дор хэрэглэж тогтсон үг, сюзеренитет хэмээх үсэг болбоос хэмжээтэй эзэрхмүй хэмээсэн утга буй хэмээх бөгөөд Бидний Монгол улс болбоос сюзеренитет хэмээх үгийг эрх үгүй хэмжээтэй эзэрхэх хэмээн орчуулмой хэмээн үзэж байсан тухай Хиагтын гурван этгээдийн хэлэлцээрийн протоколд тэмдэглэгджээ. Мөн Оросын дипломатуудын гаргасан сюзеренитет хэмээх энэ үгийн агуулгын тухай Оросын Гадаад явдлын яамны сайд Сазоновоос Хүрээнд суугаа ерөнхий консул Миллерт явуулсан захидалдаа: “Бидний зөвшөөрөн хүлээсэн, Хятадаас Монголын хувьд эдлэх сюзеренитет нь тэр хоёр улсын хоорондын зөвхөн цааз хуулийн холбоо бөгөөд учир нь тэд Монгол улс бүх асуудлын талаар, тэр ч байтугай улс төрийн талаар гадаадтай харилцах эрхийг

үгүйсгэхгүй юм”¹⁹ хэмээжээ. Харин “Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэгч яамнаас Богд хаанд айлтгасан “Думдад, Орос, Монголын гэрээ бичгийн утга чанарыг тайлбарласан дэвтэр”-т энэ талаар өгүүлэхдээ: “Гадаад Монгол Думдад улсын сюзеренитетийг хүлээн зөвшөөрснөөр улс төрийн байдлаа алдсан явдал огт үгүй. Харин ч Думдад, Орос хоёр улстай хамт нийлэн зөвхөн хэлэлцэх чухал эрхийг олж авсан энэхүү гэрээ бичгийг төгсгөж байгуулаад олон улсын дунд өөрийн дотоод засгийн бүх хэрэг зүйлийг өөртөө эзэрхэх улс төр болсноо илэрхийлжээ” хэмээсэн байна. Энэ бүхэн бол Монголын улс байх эрхийг орос, хятадын төлөөлөгчид эл гурван этгээдийн гэрээ хэлэлцээрээр бүр мөсөн хориглож чадаагүй болох нь харагдаж байгаа юм.

Эл гурван улсын гэрээгээр Хятадын сюзеренитет бүхий автономит Монгол нь өөрийн нутагт хятад цэрэг оруулахгүй, өөрийн үндэсний засгийн газар, цэрэг армитай байх эрх авсан юм. Энэ бол өөрийн тусгаар тогтнолоо цаашид бүрэн утгаар нь олж авах, Монгол төрөө сэргээн мандуулах тэмцлийн нэгэн хэлбэр болсон хэмээн үзэж байна.